



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим арга
хэмжээний тухай

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Засгийн газрын 2008 оны 50, 2013 оны 38, 2016 оны 193 дугаар тогтоолыг зөрчиж, төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газарт зөвшөөрөлгүй орон сууц бариулсан, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 19 дэх заалтыг зөрчин, 10 байр талбайг 5 иргэн, аж ахуйн нэгжид түрээсэлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж, 1,633.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн зэрэг нийт 1,633.1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн удирдах зөвлөл /Б.Ганбат/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Ажиллагсдын 2014 онд ашиглалтад орсон орон сууцны 1,636.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий зоорийн давхрын байрыг дахин үнэлүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн захирал /Б.Очирбат/-д дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2. Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;


3.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэж байгааг цаашид таслан зогсоох;

0000099

3.4. Сургуулийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслэхдээ Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ыг мөрдлөг болгож байх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн
3/4 дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	1,633.1	Үндсэн хөрөнгө олж авахад зөвшөөрөл авах
2	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 19 дэх заалтыг зөрчин 10 байр талбайг 5 иргэн, аж ахуйн нэгжид түрээсэлсэн	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	-	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан хууль, тогтоомжийн дагуу төрийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуйн нэгжид түрээсэлж байх
Зөрчил, дутагдлын нийт дүн			1,633.1	